



**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС**

**ХЭЛТСИЙН 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**2021 он**

## ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2021 оны 06 дугаар сарын 10

Сүмбэр сум

### **НЭГ. Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр:**

Говьсүмбэр аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс нь Хууль, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Төрийн албаны тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон холбогдох бусад хуулиуд, Засгийн газар, ХЗДХЯам, УБЕГ-аас гаргасан шийдвэрүүдийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ “Иргэнд суурилсан төрийн бүртгэлийн үнэн ой санамжийг бий болгох, төр, иргэнийг холбосон бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, төрийн бүртгэлийн үйлчилгээгээр иргэний эрхийг хангах” эрхэм зорилгыг ханган, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгож байна.

Хэлтсийн 2021 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г хугацаанд нь боловсруулж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаар батлуулан, хэрэгжилтийг нь хангах ажлыг зохион байгуулж байна. Мөн ажилтнуудын “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г батлаж, гүйцэтгэлд нь хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж байна.

Тайлангийн хугацаанд хэлтсийн нийт албан хаагчдын хурлыг 5 удаа зохион байгуулсан бөгөөд хурлаар өнгөрсөн 14 хоногт хийсэн ажлаа дүгнэж, ирэх 14 хоногт хийх ажлаа зөвлөлдөж, тодорхой шийдвэрүүд гаргаж хэрэгжүүлдэг болно. Мөн хууль, тогтоомж, дүрэм журам, судалж танилцах, удирдлагаас өгсөн үүрэг даалгаварын биелэлт, ажилтнуудын сахилга хариуцлага ёс зүй, харилцаа, хандлагыг дээшлүүлэх асуудлуудаар заавар, чиглэл өгч, хурлын тэмдэглэл хөтөлдөг болно. Энэ хугацаанд сахилгын зөрчил гаргасан албан хаагч байхгүй болно.

### **ХОЁР. Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр:**

#### ***а) Иргэний улсын бүртгэлийн талаар:***

Д/д	Бүртгэлийн төрөл	Хагас жилийн байдлаар (5-р сарын 25-ны өдрийн байдлаар)	
		2020 он	2021 он
1.	Төрсний бүртгэл	172	161
2.	Гэрлэлт	16	16
3.	Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл	7	10
4.	Гэрлэлт сэргээлт		

5.	Үрчлэлт	5	
6.	Эцэг тогтоолт	5	
7.	Овог, эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчлөлт	1	6
8.	Нас барсны бүртгэл	31	37
9.	Аймаг, хотоос шилжин ирсэн	152	279
10.	Аймаг доторх шилжилт хөдөлгөөн	188	203
11.	Иргэний шинэчилсэн бүртгэл	101	105
12.	25,45 насны сунгалт	185	187
13.	Иргэний үнэмлэх дахин олголт	97	75
14.	Лавлагаа	656	975
15.	Үндэсний энгийн гадаад паспорт	56	81
16.	Үйлчилгээний хураамж	<b>2,2848,600</b>	<b>3,525,000</b>
17.	Тэмдэгтийн хураамж	<b>1,306,800</b>	<b>775,500</b>
	<b>НИЙТ</b>	<b>1672</b>	<b>2135</b>

**б) Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаар**

Д/ä	Бүртгэлийн төрөл	Хагас жилийн байдлаар (6-р сарын 10-ны өдрийн байдлаар)		
		2020 онд	2021 онд	
	<b>Хүлээн авсан мэдүүлэг</b>	<b>1713</b>	<b>1651</b>	
1.	- үгүй	Төрөөс хувьчилсан газар өмчлөх эрхийн бүртгэл	248	67
2.		Газар эзэмших эрхийн бүртгэл	181	89
3.		Газраас бусад үл хөдлөх хөрөнгийн анхны бүртгэл баталгаажуулалт	17	26
4.		Худалдах худалдан авах гэрээгээр өмчлөгч өөрчлөгдөх бүртгэл	134	212
5.		Бэлэглэх гэрээ	9	13
6.		Арилжих гэрээ	4	3
7.		Өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдөх бүртгэл	16	25
8.		Шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдөх	3	0
9.		Хамтран өмчлөгч өөрчлөгдөх бүртгэл	25	17
10.		Барьцаат зээлийн гэрээ	520	605
11.		Барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэл	478	529
12.		Түрээсийн гэрээ	3	2
13.		Бүртгэлд өөрчлөлт орсон	25	22
14.		Урьдчилсан тэмдэглэл	3	5
15.		Лавлагаа хуулбар	47	36
16.	<b>Үйлчилгээний орлого</b>	<b>17,688,227</b>	<b>20,707,238</b>	
17.	<b>Улсын тэмдэгтийн хураамж</b>	<b>1,621,882</b>	<b>133,191</b>	
18.	<b>Татварын орлого</b>	<b>59,199,725</b>	<b>53,246,000</b>	

**в) Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн талаар**

Д/д	Бүртгэлийн төрөл	Хагас жилийн байдлаар (6-р сарын 10-ны өдрийн байдлаар)	
		2020 онд	2021 онд
1.	ХХК	14	8
2.	ТББ	6	4
3.	Хоршоо	1	1
4.	Хуулийн этгээдийн салбар		4
5.	Хуулийн этгээдийн өөрчлөлт	36	25
6.	Дахин гэрчилгээ шинээр авсан		2
7.	Хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт хийсэн	21	18
8.	Хураасан тамга тэмдэг	3	8
9.	Тамга тэмдгийн хяналтын хуудас олголт	13	26
10.	Лавлагаа		1
11.	НИЙТ	<b>94</b>	<b>97</b>
12.	Тэмдэгтийн хураамжийн дүн (төгрөг)	<b>1,709,000</b>	<b>1,059,000</b>

### **ГУРАВ. 2021 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийг зохион байгуулсан талаар:**

УБЕГ-ын даргын тушаалаар батлагдсан Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулиар Улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг уялдуулан 4 бүлэг 16 заалт бүхий дэд төлөвлөгөөг батлан гаргаж, төлөвлөгөөний дагуу бүх ажил, арга хэмжээ бүрэн хийгдсэн болно.

УБЕГ-с томилогдсон сургалтын баг Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудад хууль, эрх зүйн болон програмын сургалтыг 2021 оны 06 сарын 01-ны өдөр зохион байгуулав. Мөн сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулах 129 лавлагааг гаргаж, сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулан хэвлэж, хэсгийн хороодод хуулийн хугацаанд нь хүргүүлэв.

Аймгийн хэмжээнд сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэлтэй үндсэн сонгогч 10720, үүнээс 6555 сонгогч саналаа өгсөн. Санал өгсөн сонгогчдоос хурууны хээгээр 6373, регистрийн дугаараар 50, түр хасав тэмдэглэгээг сэргээсэн 22, зөөврийн хайрцгаар санал өгсөн 130 сонгогч бүртгэгдэв. Сонгуулийн өдөр иргэд, улс төрийн нам, төрийн бус байгууллагуудаас ямар нэгэн зөрчил дутагдал, гомдол гараагүй болно.

Аймгийн Цагдаа, Тагнуулын байгууллагын албан хаагчдын хяналтанд сонгуулийн техник хэрэгслийг ерөнхий газраас татан авч, буцаан хүргүүлэх ажлыг зохих журмын дагуу зохион байгуулав.

### **ДӨРӨВ. Архивын ажлын чиглэлээр:**

Архивын аюулгүй байдлыг хангах үүднээс хяналтын камер, агаарын даралт, чийгшил хэмжих зориулалтын багаж, цэнэг бүхий галын хор, хүрз, тармуур, элс зэргийг байрлуулж, байрны стандартыг хангав.

УБЕГ-ын даргын 2014 оны 814 дугаар тушаалын дагуу архивын ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйн зааврын дагуу нийт 24 удаа чийгтэй цэвэрлэгээ хийж, архивын чийг, дулааныг өдөр бүр хэмжиж тэмдэглэл хөтлөн, хадгалагдаж байгаа хувийн хэргийн аюулгүй байдлыг хангаж байна.

#### **ТАВ. Бүртгэлийн хяналт шалгалтын чиглэлээр:**

Тайлангийн хугацаанд бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг 43 удаа хийсэн.

Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд хаяг буруу бүртгэгдсэн 1 иргэний зөрчлийг дүгнэлт гаргаж, зөрчлийг арилгасан.

Хяналтын улсын байцаагчийн 21 дүгнэлт үйлдэж, бүртгэлийн 6 зөрчилд зөрчлийн тэмдэглэл үйлдсэн болно. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, сонгогч шилжих журмын хэрэгжилт, СНЖ-д өөрчлөлт оруулахаар гаргасан 129 лавлагаа болон хэвлэх үйл ажиллагаанд хяналт тавьсан бөгөөд илэрсэн зөрчил дутагдал байхгүй болно.

Зөрчлийн тухай хуулиар торгох шийтгэл ногдуулсан 53 иргэнийг зөрчлийг зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны дагуу хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, аймгийн Прокурорын газарт тухай бүр нь хянуулсан. Нийт 2100000 төгрөгөөр торгосон байна.

Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд хяналт тавьж, улсын бүртгэгч нарт мэргэжил арга зүйн заавар зөвлөгөөг хэлтсийн дарга, хяналтын улсын байцаагч, улсын ахлах бүртгэгчээс өгч, бүртгэлийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Гэрчилгээ, үнэт цаасны зарцуулалтад сар бүр тогтмол хяналт тавьж, хүчингүй болсон үнэт цаасыг улсын бүртгэлийн хэлтсийн өмч хамгаалах комиссоор шийдвэрлүүлсэн. Үнэт цаас хүчингүй болгосон улсын бүртгэгч нарт алдаа гаргахгүй ажиллах талаар заавар зөвлөмж өгсөн.

#### **ЗУРГАА. Төсөв, санхүүгийн чиглэлээр:**

Хэлтсийн үндсэн болон эргэлтийн хөрөнгө, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, улирлын санхүүгийн тайлан мэдээг Улсын бүртгэлийн ерөнхий газарт PDF болон файлаар хугацаанд нь хүргүүлсэн бөгөөд Улсын бүртгэлийн ерөнхий газарт одоогийн байдлаар 26,671,008 төгрөгийг төвлөрүүлээд байна. .

Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Жилийн эцсийн байдлаар 64 мэдээ мэдээллийг хугацаанд нь оруулсан байна. Оруулбал зохих мэдээллээс оруулаагүй, хугацаа хожимдуулж оруулсан мэдээлэл байхгүй.

Бичиг хэргийн болон шатахуун авахдаа холбогдох газруудаас үнийн санал авч, хамгийн бага үнийн дүнтэй газартай гэрээ байгуулж байна.

#### **ДОЛОО: Бусад зохион байгуулсан ажлын чиглэлээр:**

Аймгийн Засаг даргын “Иргэний баримт бичгийн үзлэг зохион байгуулах тухай” 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/412 захирамжаар иргэний баримт бичиг, шилжилт хөдөлгөөний хаягийн бүртгэлийг цэгцлэх, үзлэг зохион байгуулах ажлын хэсгийг томилж, удирдамж болон ажлын төлөвлөгөөг батласан болно. Захирамжийн дагуу аймгийн хэмжээний 57 байгууллагын 2357 албан хаагчийн судалгааг гаргуулж, иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд шалгаж, 26 байгууллагын 226 албан хаагч өөр аймаг, нийслэлийн харьяалалтай байсныг илэрүүлж, албан газруудад нь улсын байцаагчийн албан шаардлагыг хүргүүлж зөрчлийг 100 хувь арилгуулсан. Үр дүнд нь 226 иргэн бүртгүүлж, засаг захиргааны завсардал арилсан болно.

Албан бичиг хөтлөлтийн хүрээнд ABLE, төрийн байгууллагын цахим шуудангийн [www.email.gov.mn](http://www.email.gov.mn) системийг тус тус ашиглаж байна. Улсын бүртгэлийн ерөнхий газраас баталсан хуваарийн дагуу сар, улирлын улсын бүртгэлийн үйлчилгээний тоон мэдээ, тайлан, үнэт цаасны зарцуулалтын тайлан тооцоог хугацаанд нь үнэн зөв гарган хүргүүлж, баталгаажуулж хэвшсэн.

Дээд газраас ирүүлсэн албан бичиг, чиглэлийн дагуу холбогдох тайлан мэдээ, судалгааг тухай бүр хугацаанд нь гарган хүргүүлэв.

Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчдийн 2021 оны сургалтын төлөвлөгөөг баталсан бөгөөд хагас жилийн байдлаар биелэлт 45 хувьтай байна.

Тухайлбал:

-Аймаг орон нутгаас зохион байгуулсан сургалтуудад албан хаагчдыг бүрэн хамруулсан.

-Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудад зориулсан 2 удаагийн эрх зүйн цахим сургалтанд итгэмжлэгдсэн ажилтнаар ажиллах 13 албан хаагчид тус тус бүрэн хамрагдсан.

-Хэлтсийн бүх албан хаагчид Монгол Улсын засгийн газраас хэрэгжүүлж буй “Үр дүнд суурилсан бодлого төлөвлөлт, хяналт-шинжилгээ үнэлгээ” цахим сургалтанд хамрагдаж, гэрчилгээ авсан.

-Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэн, Эд хөрөнгө, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар, Хяналт шалгалтын газар, Санхүү төлөвлөлтийн газраас зохион байгуулсан нийт 14 удаагийн онлайн сургалтанд давхардсан тоогоор 21 албан хаагч бүрэн хамрагдсан.

Хэлтсийн албан хаагчдын үйлчилгээний стандартын хэрэгжилтэнд байнгын хяналт тавьж байна. Үйлчилгээний ил тод байдлыг хангах зорилгоор хэлтсийн ажлын байр, үйлчилгээний танхим болон 3 суманд мэдээллийн самбар, саналын хайрцаг ажиллуулж, 70541890, 70543056 дугаарын утсуудаар мэдээлэл, зөвлөгөөг тогтмол өгч байна. Хагас жилийн байдлаар байдлаар давхардсан тоогоор 1551 иргэн утсаар зөвлөгөө мэдээлэл авсан ба иргэдээс ямар нэгэн гомдол гаргаагүй байна.

“Улсын бүртгэлийн дуудлагын үйлчилгээ”-ээр буюу хүндэтгэн үзэх шалтгааны улмаас үйлчилгээний танхимд хүрэлцэн ирэх боломжгүй иргэдийн хүсэлтийн дагуу, улсын бүртгэгч байгаа газарт нь очиж бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн бөгөөд хагас жилийн байдлаар нийт 21 иргэнд бүртгэлийн үйлчилгээ үзүүлэв.

Эхний хагас жилийн байдлаар <http://govisumber.burtgel.gov.mn/> цахим хуудсанд 77 мэдээ, мэдээллийг байршуулсан бөгөөд хэвлэл мэдээллийн хэрэгслээр 2 удаа иргэдэд мэдээ, мэдээлэл хүргэсэн байна.

Хэлтсийн мэдээлэл технологийн ажилтан тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах болон цахим мэдээллийн санд байнгын хяналт тавьж байна. Комьпютер, тоног төхөөрөмжүүдэд 17 удаа засвар, үйлчилгээ хийсэн. Мөн комьпютер болон мэдээллийн санд нэвтрэх нууц кодыг солих зааврыг тухай бүр тогтмол өгдөг болно.

Дэлхий нийтийг хамарсан ковид-19 цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор өөрсдийн нөөц боломжиндоо тулгуурлан албан хаагчдад амны хаалт, гар ариутгагч, бээлий тус тус олгож, мэргэжлийн байгууллагаар ажлын байрыг 2 удаа ариутгах ажлыг зохион байгуулав.

Мөн Ковид-19 вирусын шинжилгээнд албан хаагчдыг бүрэн хамруулж, урьдчилан сэргийлэх 2 удаагийн вакцинд хамруулсан болно.

Хэлтсийн иргэдэд үйлчлэх танхимд Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэмжлэгтэйгээр мэргэжлийн байгууллагаар засвар үйлчилгээ хийж, өрөө тасалгааг 4 дахин томсгож, албан хаагчдын ажиллах нөхцөл, боломжийг бий болгов.



**Өмнө нь**



**Одоо**

Уламжлалт сар шиний баярыг тохиолдуулан тус хэлтсээс өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадуудаа хүлээн авч хүндэтгэл үзүүллээ.

Үндэсний мод тарих өдрийг тохиолдуулан өөрийн хариуцсан талбайдаа 12 ширхэг улиас модыг тарьж суулгалаа. Мөн тарьсан мод, бутгаа арчилж, усалгааг нь хуваарийн дагуу тогтмол хийсэн болно.

Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан албан хаагчдын хүүхдүүдэд бэлэг гардуулж, баярлуулав.

## **УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС**

